# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 27 (164)

**Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг:**

- *Улсын Их Хурлын анхдугаар чуулганыг товлон зарлах тухай*

**Монгол Улсын Засгийн Газрын тогтоол**

- *Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2000 он

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2000 оны долдугаар сарын 19 № 27 (164)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

270. Аазайн Санжжавт Монгол Улсын гавьяат тээвэрчин цол хүртээх тухай Дугаар 90 498

271. Дарамын Даримаад Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай Дугаар 91 498

272. Паануутийн Дамдинжавт Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай Дугаар 92 498

273. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай Дугаар 93 498

274. Дашдондогийн Энх-Эрдэнийг "Шударга журам" медалиар шагнах тухай Дугаар 94 500

275. Цэнгэлцогтын Гэрэлцогтыг "Шударга журам" медалиар нэхэн шагнах тухай Дугаар 95 501

276. Чойжилжавын Цэрэннадмидад Монгол Улсын эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан цол хүртээх тухай Дугаар 99 501

277. Цэнд-Аюушийн Нямжавт Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай Дугаар 100 501

278. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай Дугаар 101 501

279. Батмагнайн Загдрагчаад Монгол Улсын Хүний гавьяат эмч цол хүртээх тухай Дугаар 102 503

280. Борын Ринад Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай Дугаар 103 503

281. Говь-Алтай аймгийн зарим иргэнийг одон, медалиар шагнах тухай Дугаар 104 503

282. Хан Донг Гваныг "Найрамдал" медалиар шагнах тухай Дугаар 105 505

283. Улсын Их Хурлын анхдугаар чуулганыг товлон зарлах тухай Дугаар 113 505

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

284. Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай Дугаар 86 506

285. Төлөвлөгөө батлах тухай Дугаар 88 506

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2000 оны 6 дугаар сарын 20-ны өдөр** | **Дугаар 90** | **Улаанбаатар хот**

### Аазайн Санжжавт Монгол Улсын гавьяат тээвэрчин цол хүртээх тухай

Авто тээврийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж баазынхаа тээвэрчдийн хөдөлмөрийг оновчтой зохион байгуулж, цаг үеийн тээврийн ажлыг шуурхай гүйцэтгэхэд тогтвортой амжилт гаргаж байгааг нь үнэлж Нийслэлийн "Авто тээвэр тав" ХК-ийн дэд захирал, компанийн зөвлөх Аазайн Санжжавт Монгол Улсын гавьяат тээвэрчин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2000 оны 6 дугаар сарын 20-ны өдөр** | **Дугаар 91** | **Улаанбаатар хот**

### Дарамын Дариймаад Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай

Эрүүл мэндийн салбарт олон жил санаачлага, үр бүтээлтэй ажиллаж эх барих-эмэгтэйчүүдийн клиникийг материаллаг бааз, боловсон хүчнээр бэхжүүлэх, эмчилгээний орчин үеийн шинэлэг аргыг нэвтрүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Эх нялхсын эрдэм шинжилгээний төвийн эх барих эмэгтэйчүүдийн клиникийн ерөнхий зөвлөх эмч Дарамын Дариймаад Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2000 оны 6 дугаар сарын 20-ны өдөр** | **Дугаар 92** | **Улаанбаатар хот**

### Паануугийн Дамдинжавт Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Соёл урлагийн байгууллагыг олон жил удирдаж, нийтийн болон найрал дууны ая, дуу, бүжгийн цоморлиг, дуулалт жүжгийн хөгжмийн төрлөөр олон бүтээл туурвиж мэргэжлийн урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Дархан-Уул аймгийн "Залуучууд" театрын дарга, уран сайхны удирдагч Паануугийн Дамдинжавт Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2000 оны 6 дугаар сарын 20-ны өдөр** | **Дугаар 93** | **Улаанбаатар хот**

### Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Үйлдвэр, худалдаа, үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг, спорт, мэдээлэл, шүүх, прокурор, цагдаа, батлан хамгаалах, төр захиргаа болон төрийн бус байгууллагад олон жил амжилт гарган ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

**ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:**

1.Дамбын Даваа -Иргэний нисэхийн ерөнхий газрын Дорнод аймаг дахь нисэх буудлын дарга
2. Данзангийн Дэжидмаа -Нийслэлийн "Хасу-Манал" хувийн эмнэлгийн зөвлөх эмч
3. Намбарын Лхагвадорж - Нийслэлийн гүүр барилгын "Ган-гүүр" ХХК-ийн бригадын дарга

4. Ичинхорлоогийн Магванжав - Иргэний нисэхийн ерөнхий газрын нислэгийн хөдөлгөөний албаны мэргэжилтэн
5. Гонгоосүрэнгийн Оюунболд - Мэргэжлийн боксын "Чингэс" клубын дасгалжуулагч
6. Даржаагийн Сүрэнхорлоо -"МИАТ" компанийн АН-2 онгоцны хэсгийн дарга
7. Шалзадын Сэржхүү - Үндэсний статистикийн газрын бизнес статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
8. Бадарчийн Сэр-Од -Олон улсын нисэх буудлын Аэродромын албаны дарга
9. Бадрахын Хатанмагсар - Сэлэнгэ аймгийн Цагаануур сумын "Баяндулаан уул" ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Сагилын Алтанцэцэг - Нийслэлийн Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга
2. Рахатханы Акремхан - Баян-Өлгий аймгийн Өлгий сум дахь Багшийн коллежийн зөвлөх багш
3. Мэнонгийн Баатарсүх - Сүхбаатар аймгийн Халзан сумын Засаг дарга
4. Найданбазарын Батдорж - Нийслэлийн 84-р дунд сургуулийн хичээлийн эрхлэгч
5. Батсүхийн Батмөнх - Үндэсний статистикийн газрын дэд дарга
6. Батлайн Баяраа - Завхан аймгийн эрчим хүчний нэгдсэн үйлдвэрийн усан цахилгаан станц хариуцсан орлогч дарга
7. Жамъянгийн Баяртсайхан - Дундговь аймгийн нефть хангамжийн баазын ерөнхий инженер
8. Одсорын Буд - Нийслэлийн Баянзүрх дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний төвийн дарга
9. Дашнямын Бужидмаа - Улсын циркийн ахмад жүжигчин
10. Жалцавын Бямба - Дорнод аймгийн прокурор
11. Хамбарын Володя - Үнэт цаасны хорооны хяналт шалгалтын хэлтсийн дарга
12. Төгсжаргалын Ганди - Монгол Улсын Их Хурлын гишүүн
13. Дамдинсүрэнгийн Гансүх - Сүхбаатар аймгийн шүүхийн шүүгч, ерөнхий шүүгч
14. Ринчинжавын Гантөмөр - Иргэний нисэхийн ерөнхий газрын Техникийн хангалтын албаны инженер
15. Алтанхуягийн Гэрэлтуяа - Үндэсний статистикийн газрын Хүн ам, тооллого судалгааны товчооны орлогч дарга
16. Мөнхнасангийн Дамирансүрэн - Монгол Улсын Дээд шүүхийн шүүгч
17. Төмөрийн Дашням -Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Нийтлэг үйлчилгээний газрын дарга
18. Дагвын Дуламжав - Нийслэлийн үйлдвэрлэл,үйлчилгээ, барилга угсралтын "Пума" ХХК-ийн өрөгч, мастер
19. Жамъянгийн Жадамбаа - Үнэт цаасны хорооны албаны дарга
20. Дүгэрхүүгийн Жамбалдорж - Үндэсний статистикийн газрын Төрийн захиргааны удирдлага, мэдээллийн газрын мэргэжилтэн
21. Гэцэгийн Жаргал - Нийслэлийн Авто замын засвар, арчлалтын нэгтгэлийн бульдозерчин
22. Лувсангийн Жигээ - Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын "Шивээ-Овоо" ХК-ийн борлуулалтын менежер
23. Хуатханы Мамадиль - Баян-Өлгий аймгийн прокурорын туслах
24. Очирбалын Нарангэрэл - Завхан аймгийн Улиастай сумын Засаг даргын Тамгын газрын түшмэл
25. Батсуурийн Нарантуяа - Монголын радио, телевизийн Хэрэг эрхлэх газрын "Монголын дуу хоолой" радио станцын захирал
26. Дашзэвгийн Норжмоо - Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Долигон зоог" ХХК-ийн ерөнхий захирал
27. Сүрэнгийн Пүрэв - Дархан-Уул аймгийн прокурорын туслах
28. Хорхойн Очирбат - Увс аймгийн Улаангом сумын "Ус-Эрдэнэ" ХХК-ийн захирал
29. Багиманы Саулетхан - Баян-Өлгий аймгийн Эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга
30. Чиясангийн Төмөрчөдөр - Нийслэлийн Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спорт сургалтын төвийн захирал
31. Сосоржавын Төрбат - Сэлэнгэ аймгийн Түшиг сумын "Зэлтэр" ХХК-ийн тракторч, комбайнч
32. Данзандоржийн Түвшинбаяр - Үндэсний дуу бүжгийн "Түмэн эх" чуулгын морин хуурч
33. Ходройн Хишигдулам - Нийслэлийн 2 дугаар цэцэрлэгийн эрхлэгч
34. Баасангийн Цогням - Монгол Улсын Дээд шүүхийн шүүгч

35. Цэрэндоржийн Цэвэлравжаа - Үнэт цаасны хорооны бичээч-операторч

36. Хаянхярваагийн Цэнджав - Сэлэнгэ аймгийн Түшиг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн дарга

37. Сэрээтэрийн Чимэдсэнгэ - Хөвсгөл аймгийн Мөрөн сум дахь авто зам засварын "Хөвсгөл зам" ХХК-ийн жолооч

38. Долгорын Чулуунцэцэг -Монголын радио, телевизийн Хэрэг эрхлэх газрын "Монголын дуу хоолой" радиогийн сурвалжлагч, редактор

**ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:**

1. Содномдагвын Батхуяг - Гал түймэртэй тэмцэх газрын Төрийн ордны галын хэсгийн туслах байцаагч, ахлах ахлагч

2. Дашзэвэгийн Доодамба - Цагдаагийн ерөнхий газрын хэв журмын хэлтсийн наркологийн хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа

3. Цэрэндоржийн Хүрэлбаатар - Зэвсэгт хүчний ерөнхий штабын Улсыг агаарын довтолгооноос хамгаалах цэргийн командлалын нисдэг тэрэгний байцаагч-нисгэгч, дэд хурандаа

4. Ринченгийн Шагдарсүрэн - Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний ерөнхий штабын Иргэний нисэхийн төлөөлөгч, дэд хурандаа

**ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:**

1. Пүрэвжалбын Ганаа - Дундговь аймгийн Дэрэн сумын дунд сургуулийн захирал

2. Дамдины Мягмаржав - Зэвсэгт хүчний 137 дугаар ангийн онгоц, нисдэг тэрэг хадгалах тасгийн дарга, хошууч

3. Нүрзэдийн Нина -Сэлэнгэ аймгийн түшиг сумын "Зэлтэр" ХХК-ийн үтрэмийн ажилчин

4. Дамдинсүрэнгийн Нэргүй -Сэлэнгэ аймгийн Түшиг сумын "Зэлтэр" ХХК-ийн тракторч, комбайнч

5. Лувсанчүлтэмийн Нямдагва - Үнэт цаасны хорооны зах зээлийн зохицуулалтын хэлтсийн дарга

6. Дарьхүүгийн Оюун - Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын санхүүгийн хэлтсийн дарга

7. Балсанжавын Өлзийжаргал - Нийслэлийн 100 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

8. Загдын Тоня - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн халамж үйлчилгээний төвийн дарга

9. Батмөнхийн Түвшинжаргал - Иргэний нисэхийн ерөнхий газрын Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны орон нутгийн нислэгийн удирдагч

10. Хандгуний Халзхүү - Зэвсэгт хүчний 109 дүгээр ангийн уурын зуухны слесарьч

11. Баатарын Халтар - Ховд аймгийн Жаргалант сумын 4 дүгээр дунд сургуулийн бага ангийн багш

12. Дамдинжавын Цэвэлмаа - Сүхбаатар аймгийн сум дундын шүүхийн шүүх хуралдааны нарийн бичгийн дарга

13. Тайвангийн Шагдар - Сэлэнгэ аймгийн Түшиг сумын "Зэлтэр" ХХК-ийн тракторч, комбайнч

14. Лхампрангийн Шилэнхүү - Сэлэнгэ аймгийн Түшиг сумын "Зэлтэр" ХХК-ийн токарьчин

15. Даваагийн Чимгээ - Иргэний нисэхийн ерөнхий газрын Завхан аймгийн Булнай сум дахь Тосонцэнгэлийн нисэх буудлын нислэгийн удирдагч

16. Дулмаагийн Энхтуяа - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны удирдлагын хэлтсийн орлогч дарга

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2000 оны 6 дугаар сарын 20-ны өдөр** **Дугаар 94** **Улаанбаатар хот**

**Дашдондогийн Энх-Эрдэнийг "Шударга журам" медалиар шагнах тухай**

Эр зориг, авхаалж самбаа гарган, үерийн уснаас хүүхдийн амь аварч, иргэний үүргээ нэр төртэй биелүүлсэн Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын 808 дугаар ангийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Дашдондогийн Энх-Эрдэнийг "Шудрага журам" медалиар шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 6 дугаар сарын 20-ны өдөр | Дугаар 95 | Улаанбаатар хот

**Цэнгэлцогтын Гэрэлцогтыг "Шударга журам" медалиар нэхэн шагнах тухай**

Усанд живсэн хүний амийг аврахаар эр зориг, хүнлэг ариун сэтгэл гарган тэмцэж, амь эрсэдсэн Техникийн их сургуулийн харьяа Дархан-Уул аймаг дахь Технологийн их сургуулийн 2 дугаар дамжааны оюутан асан Цэнгэлцогтын Гэрэлцогтыг "Шудрага журам" медалиар нэхэн шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 6 дугаар сарын 27-ны өдөр | Дугаар 99 | Улаанбаатар хот

**Чойжилжавын Цэрэннадмидад Монгол Улсын Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан цол хүртээх тухай**

Эрүүл мэндийн салбар болон эмнэлгийн байгууллагуудыг олон жил үр бүтээлтэй удирдаж, эмнэлэгийн үйлчилгээний бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, дотрын өвчин, цусны эмгэг судлалын албыг хөгжүүлэх, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Анагаах ухааны их сургуулийн цусны эмгэг судлалын салбарын профессор Чойжилжавын Цэрэннадмидад Монгол Улсын эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 6 дугаар сарын 27-ны өдөр | Дугаар 100 | Улаанбаатар хот

**Цэнд-Аюушийн Нямжавт Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай**

Мэдээллийн байгууллагад удаан жил үр бүтээлтэй ажиллаж нийгмийн өөрчлөлт шинэчлэлийн бодлого, хэрэгжилт, нийслэлийн ажил амьдралын талаар олон сурвалжлага, нийтлэл, мэдээ бэлтгэж, сонсогчдод хүргэн сурталчлахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Нийслэлийн "Дөрвөн-Уул" радиогийн сурвалжлагч, ахлах редактор Цэнд-Аюушийн Нямжавт Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 6 дугаар сарын 27-ны өдөр | Дугаар 101 | Улаанбаатар хот

**Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай**

Үйлдвэр, үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг, хөдөө аж ахуй, төр захиргааны байгууллагад олон жил ажмилт гарган ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

**ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:**

1. Сангийн Бямбасүрэн -Дорнод аймгийн Дулааны цахилгаан станцын инженер

2. Дагвасамбуугийн Дэнсамбуу - Архангай аймгийн хөдөөгийн ядуурлыг бууруулах төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохицуулагч
3. Жанцангийн Моонон - Хэнтий аймгийн Батноров сумын "Жоншит тээвэр" ХК-ийн жолооч

**"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:**

1. Самбуугийн Баатар - Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Засаг даргын Тамгын газрын дарга
2. Эрэвгийн Борхүү - Дархан-Уул аймгийн Дархан сумын 17 дугаар дунд сургуулийн захирал
3. Цэдэнбалын Ганбаатар - Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Нийтийн аж ахуй, үйлчилгээний газрын худаг засварын мастер
4. Дэнзэнгийн Дэнсмаа - Өвөрхангай аймгийн Хужирт сумын нэгдсэн эмнэлгийн халдвартын тасгийн эрхлэгч
5. Балбарын Лодон - Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын малчин
6. Цэдэндашийн Лувсаншарав - Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын түшмэл
7. Зундуйн Майнжав - Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 2 дугаар дунд сургуулийн бага ангийн багш
8. Цэндийн Оюунбаатар - Хэнтий аймгийн ардын дуу, бүжгийн "Хан Хэнтий" чуулгын бүжиг дэглэгч
9. Сонинхүүгийн Оросоо - Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын "Жавхлант хараа" ХХК-ийн үтрэмийн эрхлэгч
10. Цэнджавын Уранчимэг - Сүхбаатар аймгийн Дарьганга сумын дунд сургуулийн бага ангийн багш
11. Увшнасангийн Цэндхүү - Төв аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны ажилтан
12. Лхамжавын Чойжинням - Дорнод аймаг дахь Багшийн коллежийн захирал
13. Долгорын Шоовдор - Өмнөговь аймгийн Даланзадгад сумын "Гүний ус" ҮҮГ-ын үйлчлэгч

**ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:**

1. Ёндонжамцын Алтанцэцэг - Өмнөговь аймгийн Эрчим хүчний үйлдвэрийн зэлжийн цахилгаанчин
2. Жасрайн Баярмагнай - Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын Засаг дарга
3. Дамдинсүрэнгийн Гүнсэнноров - Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын Засаг даргын Тамгын газрын дарга
4. Гэндэнжамцын Жагдагсүрэн - Хэнтий аймгийн Батноров сумын Бэрхийн уулын үйлдвэрийн жолооч
5. Нэрэнсангийн зангад - Хэнтий аймгийн Батноров сумын Бэрхийн уулын үйлдвэрийн нэвтрэгч
6. Донгиндовын Лхасүрэн - Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын "Сэлэнгэ мөрөн" ХХК-ийн захирал
7. Гэндэнгийн Лхамсүрэн - Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 4 дүгээр дунд сургуулийн биологийн багш
8. Жамъянгийн Магсар - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн өндөр настан
9. Дамдинпүрэвийн Норжин - Дархан-Уул аймгийн Шарын гол сумын эрүүл мэндийн төвийн лаборант
10. Цэдэнбалжирын Оюунгэрэл - Дархан-Уул аймаг дахь Техникийн коллежийн дулааны тэнхмийн эрхлэгч
11. Жанамханы Сука - Сэлэнгэ аймгийн Шаамар сумын "Ундрагч" ХХК-ийн тракторч
12. Доржийн Сумъяа - Архангай аймгийн Өндөр-Улаан сумын цэцэрлэгийн эрхлэгч
13. Цэрэндоржийн Сэрээтэр - Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газрын зохион байгуулагч
14. Лундаагийн Төмөрбаатар - Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын "Чагтай" ХХК-ийн тракторч, комбайнч
15. Лхагважавын Төмөрбаатар - Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын "Жугнай" ХХК-ийн захирал
16. Дамдинжавын Төмөрпүрэв - Дорнод аймгийн "Адуунчулуун" ХК-ийн засварчин
17. Цэрэнгээгийн Тунгалаг - Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 1 дүгээр эмийн сангийн жор баригч
18. Муумын Цэрэндаш - Төв аймгийн "Төв-Ус" ХК-ийн жолооч
19. Сэрээтэрийн Эрдэнэцогт - Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын "Ургац-Хүдэр" ХХК-ийн тракторч, комбайнч

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2000 оны 7 дугаар сарын 5-ны өдөр** **Дугаар 102** **Улаанбаатар хот**

**Батмагнайн Загдрагчаад Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай**

Эрүүл мэндийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж эмчилгээ, оношлогооны дэвшилтэт аргуудыг нэвтрүүлэх, хөдөөгийн хүн амд мэс заслын нарийн мэргэжлийн тусламж үзүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Говь-Алтай аймгийн нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасгийн их эмч Батмагнайн Загдрагчаад Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2000 оны 7 дугаар сарын 5-ны өдөр** **Дугаар 103** **Улаанбаатар хот**

**Борын Ринад Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай**

Мэргэжлийн урлагийн байгууллагад олн жил үр бүтээлтэй ажиллаж монгол ардын болон зохиолын дуунуудыг чадварлаг дуулж, дуулалт жүжгийн дүрд амжилттай тоглож, хөдөөгийн хөдөлмөрчдөд урлаг соёлоор үйлчлэх үйлсэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Говь-Алтай аймгийн Ардын дуу, бүжгийн "Алтай" чуулгын гоцлол дуучин Борын Ринад Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2000 оны 7 дугаар сарын 5-ны өдөр** **Дугаар 104** **Улаанбаатар хот**

**Говь-Алтай аймгийн зарим иргэнийг одон, медалиар шагнах тухай**

Говь-Алтай аймгийн үйлдвэрлэл, үйлчилгээ, соёл, боловсрол, эрүүл мэндийн салбар, төр захиргааны байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг Говь-Алтай аймаг байгуулагдсаны 60 жилийн ойг тохиолдуулан одон, медалиар шагнасугай.

**ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:**

1. Ядамсүрэнгийн Базар -Говь-Алтай аймгийн Эрчим хүчний үйлдвэрийн инженер
2. Норовын Гүнд -Говь-Алтай аймгийн Байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх газрын дарга
3. Чоймжуурын Цэрэнхүү -Говь-Алтай аймгийн Тайшир сумын Засаг дарга

**"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:**

1. Уваажийн Алтанцэцэг -Говь-Алтай аймгийн Бигэр сумын Засаг даргын Тамгын газрын ажилтан
2. Баасангийн Аюуш -Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын малчин
3. Гун-Аажавын Бааран -Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын Засаг дарга
4. Бамбарын Баасанхүү -Говь-Алтай аймгийн шүүхийн ерөнхий шүүгч
5. Сумъягийн Бархаа - Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын түшмэл
6. Гаанжуурын Бямбажав -Говь-Алтай аймгийн Хянан шалгах хорооны дарга
7. Цэдэнбалын Гаанжуурсүрэн -Говь–Алтай аймгийн Цогт сумын малчин
8. Жовжидын Гаваа -Говь-Алтай аймгийн Есөн-Булаг сумын "Тулга-Алтай- ХК-ийн дэд дарга
9. Ламжавын Дамбасүрэн -Говь-Алтай аймгийн Засаг даргын тамгын газрын Ядуурлыг

буурuулах зөвлөлийн дарга
10. Гүнсэнгийн Дамбийням -Говь-Алтай аймгийн Бугат сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн дарга
11. Банзрагчийн Дашдагжид -Говь-Алтай аймгийн Газар хөдлөлийг судлах станцын ажиглагч
12. Төрбатын Дашням -Говь-Алтай аймгийн Шуудан холбооны албаны дарга
13. Санжийн Даян - Говь-Алтай аймгийн Засаг даргын дэргэдэх татварын хэлтсийн дарга
14. Борын Дорждагва - Говь-Алтай аймгийн МАХН-ын хорооны дэд дарга
15. Намсрайн Жадамба -Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын дулаан хангамжийн "Илч-Алтай" ХХК-ийн тракторч
16. Чойжилжавын Жуваадорж -Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 3 дугаар дунд сургуулийн газар зүйн багш
17. Дүгэржавын Загдрагчаа -Говь-Алтай аймгийн Жаргалан сумын дунд сургуулийн монгол хэл, уран зохиолын багш
18. Сандагийн Ившинхорол -Говь-Алтай аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
19. Балжийн Лхагва -Говь-Алтай аймгийн ардын дуу, бүжгийн "Алтай" чуулгын гоцлол дуучин
20. Дагшинжавын Лхагвасүрэн -Говь-Алтай аймгийн радио-телевизийн сурвалжлагч
21. Цэгмэдийн Лхагвасүрэн -Говь-Алтай аймгийн засаг даргын дэргэдэх Гал түймэртэй тэмцэх хэлтсийн ахлах нягтлан бодогч
22. Гончигийн Маньбазар -Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн дарга
23. Бухаагийн Санждамба -Говь-Алтай аймгийн Цогт сумын Баянтоорой тосгоны хүн эмнэлгийн салбарын эрхлэгч
24. Сандагийн Сурьяа -Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн өрхийн их эмч
25. Лодойн Сэржгочоо -Говь-Алтай аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн ахлах байцаагч
26. Цэдэвийн Сэрээжав - Говь-Алтай аймаг дахь анагаах ухааны коллежийн багш
27. Цагааны Түвдэн -Говь-Алтай аймгийн Засаг даргын тамгын газрын дэс түшмэл
28. Түвдэнгийн Пүрэв -Говь-Алтай аймгийн Тонхил сумын дунд сургуулийн хичээлийн эрхлэгч
29. Дашнямын Халтардух -Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын тамгын газрын нийгмийн даатгалын улсын байцаагч
30. Мажигийн Цагаанхүү -Говь-Алтай аймгийн Алтай сумын малчин
31. Гончигийн Цэрэнбал -Говь-Алтай аймгийн Төгрөг сумын Засаг даргын Тамгын газрын түшмэл
32. Ламжавын Эрдэнэсүрэн -Говь-Алтай аймгийн Бугат сумын хүн эмнэлгийн салбарын эрхлэгч, их эмч

## ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Лхагважавын Баавгай -Говь-Алтай аймгийн Нефть хангамжийн баазын жолооч
2. Цэдэвийн Бадамрагчаа -Говь-Алтай аймгийн Тонхил сумын хүн эмнэлгийн бага эмч
3. Замбагын Баттулга -Говь-Алтай аймгийн Шарга сумын Засаг даргын орлогч
4. Сандагсүрэнгийн Бодь -Говь-Алтай аймгийн Тонхил сумын малчин
5. Бэгзийн Бямбаа -Говь-Алтай аймгийн Тайшир сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн дарга
6. Сандагийн Ванчиг -Улсын нөөцийн газрын Говь-Алтай аймаг дахь салбарын эрхлэгч
7. Бавуудоржийн Гүнсэн -Говь-Алтай аймгийн Төгрөг сумын Засаг дарга
8. Балдангийн Дашдаваа -Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Засаг даргын орлогч
9. Чогсомын Долзод -Говь-Алтай аймгийн Засаг даргын тамгын газрын түшмэл
10. Анандын Доржбал -Говь-Алтай аймгийн усны аж ахуйн "Ундраа" ХХК-ийн өрмийн мастер
11. Даржаагийн Дорждэрэм -Говь-Алтай аймгийн Жаргалан сумын малчин
12. Дашийн Дэмбээ -Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
13. Самбуугийн Жаргалсайхан -Говь-Алтай аймгийн Бигэр сумын үйлдвэр худалдааны "Шимт дээж" ХХК-ийн захирал
14. Баатарын Жигжээ - Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын түшмэл
15. Янжмаагийн Жигмэд -Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын дулаан хангамжийн "Илч-Алтай" ХХК-ийн ахлах слесарьч
16. Шаншийн Лувсанжамц - Говь-Алтай аймаг дахь Нефть хангамжийн баазын дарга
17. Самбын Маамба - Говь-Алтай

аймгийн Цогт сумын мал эмнэлэг, үржлийн албаны улсын байцаагч
18. Гомбосүрэнгийн Мягмар -Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын малчин
19. Балбарын Нурмаажав -Говь-Алтай аймгийн Холбооны газрын залгагч
20. Содномын Рэнцэндорж -Говь-Алтай аймгийн Засаг даргын дэргэдэх статистикийн хэлтсийн дарга
21. Батжаргалын Пүрэвбаатар -Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын хот тохижуулах ангийн жолооч
22. Данаажавын Сүхбал -Говь-Алтай аймгийн Эрчим хүчний үйлдвэрийн борлуулалтын байцаагч
23. Жамъянгийн Сэржповрон -Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын барилга угсралтын "Арвин бэлт" ХХК-ийн захирал
24. Боролзойн Өлд - Говь-Алтай аймгийн Алтай сумын Засаг даргын Тамгын газрын нийгмийн даатгалын байцаагч
25. Галсангийн Тогтох - Говь-Алтай аймгийн Төгрөг сум дахь сум дундын нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч
26. Дампилын Түмхүү - Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийн эрхлэгч
27.Жадамбаагийн Тэрбиш -Говь-Алтай аймгийн ардын дуу бүжгийн "Алтай- чуулгын гоцлол хөгжимчин
28. Ядамжавын Хажидмаа -Говь-Алтай аймгийн Шарга сумын Засаг даргын тамгын газрын түшмэл
29. Түвдэнгийн Чимэд -Говь-Алтай аймгийн Хөдөө аж ахуйн газрын мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн эмч
30. Палчийн Чулуун -Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 1 дүгээр дунд сургуулийн зураг хөдөлмөрийн багш
31. Далхжавын Чүлтэм -Говь-Алтай аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн ахлах инженер
32. Номхоны Юмжиг -Говь-Алтай аймгийн Шарга сумын дунд сургуулийн захирал

**ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:**

1. Ямааранзын Бүрнээбаатар -Говь-Алтай аймгийн Засаг даргын дэргэдэх цэрэг, иргэний хамгаалалтын штабын офицер, дэд хурандаа
2. Цэен-Ойдовын Эрдэнэ -Говь-Алтай аймгийн Засгийн даргын дэргэдэх цэрэг, иргэний хамгаалалтын штабын офицер, дэд хурандаа

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2000 оны 7 дугаар сарын 5-ны өдөр** **Дугаар 105** **Улаанбаатар хот**

**Хан Донг Гваныг "Найрамдал" медалиар шагнах тухай**

Анагаах ухааны их сургуулийн сургалт, эрдэм шинжилгээ, эмнэлгийн үйлчилгээний материаллаг баазыг бэхжүүлэх, багш нарын мэргэжлийг дээшлүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж БНСУ-ын Ионсейн их сургуулийн дэд захирал Хан Донг Гваныг "Найрамдал" медалиар шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2000 оны 7 дугаар сарын 14-ний өдөр** **Дугаар 113** **Улаанбаатар хот**

**Улсын Их Хурлын анхдугаар чуулганыг товлон зарлах тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин долдугаар зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийг баримтлан Монгол Улсын Их Хурлын гурав дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулганыг 2000 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн 10 цагт Улаанбаатар хотноо хуралдуулж эхлэхээр товлон зарласугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 6 дугаар сарын 14-ний өдөр | Дугаар 86 | Улаанбаатар хот

### Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн мөрөөр авах зарим арга хэмжээний ухай

"Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг явуулах тухай" Ерөнхий сайдын 1999 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 145 дугаар захирамжийн дагуу архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг явуулсан дүнг хэлэлцээд Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Улсын үзлэгийн явцад илэрсэн зөрчлийг арилгах, архив, албан хэрэг хөтлөлтийг боловсронгуй болгох талаар тодорхой арга хэмжээ авч ажиллахыг яам, агентлагийн удирдлага, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2.Архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтныг давтан сургах, төрийн архивуудын мэдээлэл, эрэлт хайлтын системийг боловсронгуй болгох зорилгоор зохион байгуулалтын дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хууль зүйн сайд Д.Ганболдод үүрэг болгосугай:

а/Үндэсний архивын газрын дэргэд архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтын төв байгуулах;

б/Үндэсний төв архивын сан хөмрөгийн баримтад анги төрлийн нэгдсэн каталоги зохиох ажлыг тодорхой төсөл боловсруулан хэрэгжүүлэх.

3.Үндэсний төв архивын сан хөмрөгийн баримтын хадгалалтын нөхцөлийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах зорилгоор архивын материаллаг баазыг бэхжүүлж зориулалтын тоног төхөөрөмжөөр хангах, галын дохиоллын системийг шинэчлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг 2001 оны хөрөнгө оруулалтын нэгдсэн төлөвлөгөөнд тусгуулах арга хэмжээ авахыг Сангийн сайд Я.Очирсүх, Хууль зүйн сайд Д.Ганболд нарт даалгасугай.

4.Архивын салбарт ажиллах мэргэжлийн боловсон хүчнийг улсын захиалгаар дотоод, гадаадад сургах арга хэмжээ авахыг Гэгээрлийн сайд А.Баттөр, Хууль зүйн сайд Д.Ганболд нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Р.АМАРЖАРГАЛ

ХУУЛЬ ЗҮЙН САЙД Д.ГАНБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 6 дугаар сарын 21-ний өдөр | Дугаар 88 | Улаанбаатар хот

### Төлөвлөгөө батлах тухай

"Халиун бугын үндэсний хөтөлбөр батлах тухай" Улсын Их Хурлын 2000 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 31 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Халиун бугын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г хавсралтын ёсоор баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Р.АМАРЖАРГАЛ

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД С.МЭНДСАЙХАН

Засгийн газрын 2000 оны 88 дугаар
тогтоолын хавсралт

## ХАЛИУН БУГЫН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Арга хэмжээний агуулга | Хэрэгжүүлэх хугацаа | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|
| 1. | Халиун бугын үндэсний хөтөлбөр, түүний хэрэгжилтийн явц, үр дүнг олон нийтэд сурталчлах. | 2000 оноос | Байгаль орчны яам /хэвлэл мэдээллийн болон буга хамгаалах чиглэлийн төрийн бус байгууллагуудтай хамтран/ |
| 2. | Монгол орны бугын тархац, байршил, тоо толгой, сүргийн бүтэц, нөхөн үржил, агнуурын нөөцийг судлан тогтоох. | 2000-2002 | Байгаль орчны яам, Шинжлэх ухааны академи |
| 3. | Холбогдох яам, нутгийн захиргааны байгууллагатай тохиролцсоны үндсэн дээр бугын үндсэн байршил зарим газар нутгийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах санал, үндэслэлийг боловсруулж, шийдвэрлүүлэх. | 2000-2002 | Байгаль орчны яам, аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| 4. | Бугын байршил нутгийг аж ахуйн нэгж, байгууллагад тодорхой нөхцөл болзолтойгоор гэрээний үндсэн дээр эзэмшүүлэх, ашиглуулах ажлыг зохион байгуулах. | 2000-2001 | Байгаль орчны яам, аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| 5. | Хөвсгөл, Хэнтий, Төв, Булган, Сэлэнгэ, Архангай, Өвөрхангай, Баян-өлгий, Увс, Ховд аймгуудын буга бүхий газруудын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчдыг унаа, бие хамгаалах болон холбооны хэрэгслээр хангах. | 2000-2006 | Байгаль орчны яам, Сангийн яам, холбогдох аймгийн Засаг даргын Тамгын газар |
| 6. | Бугын ясан эвэрт экспортын гаалийн татвар ногдуулах, шаардлагатай гэвэл түр хугацаагаар гадаадад гаргахыг хязгаарлах, асуудлыг судлан боловсруулж шийдвэрлүүлэх. | 2001 оноос | Байгаль орчны яам, Сангийн яам, Улсын гаалийн ерөнхий газар |
| 7. | Бугын биологи, генетик, экологийн чиглэлийн судалгааны ажлын уялдаа холбоог сайжруулж, үр өгөөжийг дээшлүүлэх. | 2000-2006 | Байгаль орчны яам, Шинжлэх ухааны академи |

| | | | |
|---|---|---|---|
| 8. | Бугыг зориудаар өсгөн үржүүлэх арга технологийг боловсруулж, заавар, зөвлөмж гаргах. | 2000-2006 | Байгаль орчны яам, эрдэм шинжилгээний байгууллагууд |
| 9. | Буга хамгаалах, өсгөн үржүүлэх чиглэлээр төсөл хэрэгжүүлэх. | 2000-2006 | Байгаль орчны яам, Гадаад харилцааны яам /Төрийн бус байгууллага, сонирхсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран/ |
| 10. | 1998-2000 онд буга согоотой холбогдон гарсан хэрэг зөрчлүүдийг хууль хяналтын байгууллагаар эцэслэн шийдвэрлүүлэх арга хэмжээ авах. | 2001 | Байгаль орчны яам, Хууль зүйн яам /Шүүх, хууль хяналтын байгууллагатай хамтран/ |
| 11. | Нийслэл, аймгуудын зах зээлийн томоохон төв /Нарантуул, Цайз зэрэг/ - үүдэд буга согоо болон бусад ангийн гаралтай түүхий эдийн худалдаалалтад хяналт тавих үүрэг бүхий байцаагч, идэвхтэнийг тодорхой хугацаагаар томилон ажиллуулах,тэднийг ажлынх нь үр дүнгээр шагнаж урамшуулах ажлыг зохион байгуулах. | 2000-2006 | Байгаль орчны яам, Цагдаагийн ерөнхий газар, Нийслэл, аймгийн Засаг даргын Тамгын газар |
| 12. | Бугын цусан эвэр бэлтгэх үйл ажиллагаа эрхлэх зорилгоор байгуулагдсан аж ахуйн нэгжүүдийн буганд им тэмдэг тавьж, улсын бүртгэл, мэдээллийн санд авах. | 2000-2006 | Байгаль орчны яам |
| 13. | Агнуурын нөөцтэй зарим нутагт тусгай төлбөртэйгээр гадаадын анчдад буга агнуулах ажлыг зохион байгуулах. | 2001-2006 | Байгаль орчны яам, холбогдох аймаг, сумын Засаг даргын Тамгын газар |
| 14. | Бугын ясан болон цусан эврийг боловсруулах, эх орны үйлдвэрт эм бэлдмэл, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагааг дэмжиж энэ ажилд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг чиглүүлэх. | 2000-2006 | Байгаль орчны яам, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам, Гадаад харилцааны яам |
| 15. | Бугын аж ахуйн зоотехникч, малын эмч, агнуур зүйчдийг богино хэмжээний сургалтад хамруулах арга хэмжээг зохион байгуулах. | 2004 | Байгаль орчны яам, Гадаад харилцааны яам, Гэгээрлийн яам, Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яам |
| 16. | ОХУ, Казахстан, БНХАУ, БНСУ, Шинэ Зеланд зэрэг улстай буга хамгаалах, үржүүлэх, бугын цусан болон ясан эврийг боловсруулах чиглэлээр хамтран ажиллах, мэргэжилтэн сургах. | 2000-2006 | Байгаль орчны яам, Гадаад харилцааны яам |

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: **"Төрийн мэдээлэл"** эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 329612
Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487